



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 3.1.3, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нисэхийн мэдээллийн үйлчилгээний автомат системийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:  
Д.Лхагважав

Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер

Нарийн бичгийн дарга:  
Ч.Ганзориг

Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

А.Ванданмагсар

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны Аюулгүй ажиллагаа, чанар хангалтын хэсгийн дарга

С.Хурц

Монголын Аэронавигаци, инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн

С.Үжин

“Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төв” төрийн бус байгууллагын гишүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо /Д.Лхагважав/-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ч.Ганзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ